2026 оны 09 сар 30 өдөр Дугаар 33 Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай

Говь ХК-ийн 2026 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосонтой холбогдуулан, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцээд, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт, Говь ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 6.2 дугаар зүйлийн 6.2.17 дахь заалтыг тус тус удирдлага болгон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Баатарсайханыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар 3 (гурван) жилийн хугацаатай сонгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Баатарсайханд Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм болон дотоод журамд нийцүүлэн удирдан зохион байгуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүргийн хэрэгжилтийг ханган, компанийн засаглалын тогтолцоог бэхжүүлэх, тасралтгүй сайжруулах чиглэлээр манлайлан ажиллахыг үүрэг болгосугай.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998...2076357

ТУЗ-ИЙН ГИШҮҮД: Ц.БААТАРСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

Б.ОРГИЛ

Ц.ОРГИЛБОЛД

Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ

GOBI

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026он 09сар 30өдөр Дугаар 34 Улаанбаатар хот

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 81-р зүйлийн 81.1, 81.2 дахь заалт, Говь ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.8, 6.2.20, 6.2.21 дэх заалтыг тус тус удирдлага болгон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосонтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын Хавсралт 1-д заасны дагуу томилсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга, гишүүдэд Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон хороодын үйл ажиллагааны журамд заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 2076357

ТУЗ-ИЙН ДАРГА Ц.БААТАРСАЙХАН

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны **09**-р сарын **30**-ны өдрийн хурлын
34-р тогтоолын **1**-р хавсралт

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998...2076357

ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Хороод		**Бүрэлдэхүүн**	
Нэр дэвшүүлэх хороо	дарга	хараат бус гишүүн	Д. Гэрэлмаа
	гишүүн	хараат бус гишүүн	Д. Хүрэлбаатар
	гишүүн	ердийн гишүүн	Д. Хулан
Цалин, урамшууллын хороо	дарга	хараат бус гишүүн	Д. Хүрэлбаатар
	гишүүн	хараат бус гишүүн	Р. Саранцэцэг
	гишүүн	ердийн гишүүн	Б. Оргил
Эрсдэл, аудитын хороо	дарга	хараат бус гишүүн	Р. Саранцэцэг
	гишүүн	хараат бус гишүүн	Д. Гэрэлмаа
	гишүүн	ердийн гишүүн	Б. Цээнам

2026 он 09 сар 30 өдөр Дугаар 35 Улаанбаатар хот

Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.10, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Говь ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 6.2 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.7.9, 6.2.8 дахь заалтыг тус тус удирдлага болгон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Компанийн 2026 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК-ийг сонгосугай.
2. "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК-тай байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д зөвшөөрсүгэй.
3. Хөндлөнгийн аудитын дүгнэлт, захидлыг хүлээн авч, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороонд танилцуулахыг Санхүү, бүртгэл хариуцсан захирал (Д.Содгэрэл)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА Ц.БААТАРСАЙХАН

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998...2076357